

## ТАНИЛЦУУЛГА

“Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

“Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилтийн талаар 2013 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хуралдааны тэмдэглэлийн дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 34 дүгээр захирамж гарч Уул уурхайн сайдаар ахлуулсан Ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг хуралдаад Дэд ажлын хэсэг байгуулан хилийн зааг, нөхөх олговор, орон нутаг, иргэдийн байр суурь, хөрөнгө оруулалт, банк санхүү болон эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, хууль, эрх зүйн чиглэлээр судалж дүгнэлт гарган цаашид авах арга хэмжээний саналын хамт Засгийн газрын 2013 оны 08 дугаар сарын 16, 23, 30-ны өдрийн хуралдаануудад танилцуулсан.

Засгийн газрын хуралдаанаас Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулахыг чиглэл болгосны дагуу “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлаас 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуулийг баталсан. Хуульд, дагаж мөрдөснөөс хойш 5 сарын хугацаанд багтаан ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг цуцлахаар заасан боловч хуулиар хориглосон талбайн хилийн заагийг тогтоох ажил удааширснаас энэ заалт хэрэгжээгүй юм.

Мөн Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолоор баталсан хилийн заагт хамаарах алтны шороон ордуудын 242 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нэхэмжилсэн 222,5 тэрбум төгрөгийн нөхөх олговор, түүнд хөндлөнгийн аудит хийх зардлын санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй байснаас хуулийн хэрэгжилт удааширч өнөөдрийг хүртэл бүрэн хэрэгжээгүй байна.

Үүний дараа 2012 оны 6 дугаар сарын 05-ны өдөр Засгийн газрын 194 дүгээр тогтоол гарч Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас /хуучин нэрээр/ тогтоосноор гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газар, ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсийг улсын хэмжээнд баталсан. Эдгээр талбайд хэсэгчлэн болон бүхэлдээ давхцалтай нийт 909 хайгуулын тусгай зөвшөөрөл, 427 ашиглалтын тусгай зөвшөөрөл тоологдсон.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид

Хүснэгт 1.

Хөрөнгө оруулалт	Ашиглалтын		Хайгуулын		Нийт	
	Т/З	ААН	Т/З	ААН	Т/З	ААН
Тоогоор	91	53	257	122	348	161
Гадаадын 100%	33	25	73	46	106	67
Хамтарсан	303	226	579	410	882	599
Дотоодын	427	304	909	578	1336	827*

\* - давхардаагүй тоогоор

Зөвхөн тусгай зөвшөөрлүүдийн төлбөр, хайгуулын талбайд оруулсан хөрөнгө оруулалтын зардал 659.5 тэрбум төгрөг (хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 155.5 тэрбум, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 52.2 тэрбум, геологи, хайгуулын ажлын зардал 451.8 тэрбум төгрөг, ам.долларын ханшийг 1480 төгрөгөөр тооцов) байх тооцоо гарч байна. Тусгай зөвшөөрлийг цуцлах тохиолдолд хамгийн багадаа ийм хэмжээний нөхөх олговор улсын төсөвт ачаалал болж ирэх юм.

Уул уурхайн салбарт хийгдэх гадаадын шууд хөрөнгө оруулалт өнгөрсөн онд 33 хувиар буурсны 6.6 хувь нь “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийг батлахдаа тооцоо судалгаа дутуу хийгдснээс шалтгаалж хөрөнгө оруулагчдын дунд болгоомжлолыг бий болгосонтой холбоотой гэж үзэхээр байна. Мөн салбараас төсөвт орох орлогын хэмжээ буурсан нь энэ хуультай тодорхой хэмжээнд хамааралтай байна. Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолд хамрагдсан алтны шороон ордуудын үйл ажиллагааг зогсоосноор алтны салбараас улсын төсөвт оруулах орлого 20 хувиар буюу 30 гаруй тэрбум төгрөгөөр буурсан байна.

“Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуулийг хэрэгжүүлэх боломжтой болно. Хуулийг дагаж мөрдөхөөс өмнө олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг цуцлах болон дуусгавар болох хүртлэх хугацаанд ашигт малтмалын хайгуул, ашиглалт, байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагааг олон нийтийн хяналтын дор явуулах журам, гэрээний загварыг Засгийн газар батлахаар өөрчлөлт оруулна. Хуулийг дагаж мөрдөхөөс өмнө болон хойно олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрөл, түүн дээр олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг энэ журмаар зохицуулахгүй болно.

Нэмэлт, өөрчлөлтөд хуулийг дагаж мөрдөхөөс өмнө олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн хилийн заагт хамаарах хэсэгт тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх өргөдөл гаргавал онцгой бүсэд үйл ажиллагаа явуулах шаардлагыг хангасан эсэхийг судлан үзэж мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулахаар тусгасан.

Үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх хүсэлт гаргаагүй болон холбогдох шаардлагыг хангаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг нөхөх олговоргүй цуцлах заалт орууллаа.

Монгол орны ойрын ирээдүйн эдийн засгийн гол тулгуур болсон уул уурхайн салбарт дээрх өөрчлөлт дараах үр, нөлөөг үзүүлнэ гэж үзэж байна. Үүнд:

- Хууль хэрэгжихгүй байгаа гацаа арилж, бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэнэ.
- Уул уурхайн үйлдвэрлэлд өртсөн байгаль орчин нөхөн сэргээгдэж, хуулиар хориглосон талбайд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шинээр олгогдохгүй болно.
- Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүд болон байгаль орчны төлөөх иргэний нийгмийн байгууллагууд харилцан ойлголцолд хүрч, хамтран ажилладаг болно.
- Аж ахуйн нэгжүүдэд нөхөх олговор олгохгүй болсноор улсын төсвийн дарамт үүсэхгүй болно.
- Хуулийн үйлчлэл тодорхой болсноор хүлээсэн байдалтай байсан хөрөнгө оруулагчдын эргэлзээ арилж уул уурхайн салбарт хийгдэх гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.
- Уул уурхайн салбараас улсын төсөвт оруулах орлого нэмэгдэнэ.

Хамгийн том үр дүн нь гол мөрний урсац бүрэлдэх эх хамгаалагдах, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагааг зогсоох, цаашдаа ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг зогсоох нөхцөл бүрдэж, энэ хууль улсын төсөвт ачаалалгүйгээр бүрэн хэрэгжих боломж бүрдэнэ.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН  
ХАМГААЛАЛТЫН БҮС, ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ,  
АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд дараахь агуулгатай 3, 4, дүгээр зүйл нэмсүгэй:

“3 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг цуцлах болон дуусгавар болох хүртлэх хугацаанд ашигт малтмалын ашиглалт, байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагааг мэргэжлийн олон нийтийн байгууллагын хяналтын дор явуулах журам, ашигт малтмалын төрөл тус бүрт тохирсон гэрээний загварыг Засгийн газар батална.

4 дүгээр зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд өргөдөл ирүүлээгүй болон 2 дугаар зүйлд заасан шаардлага хангахгүй бол тухайн ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлах бөгөөд дахин тухайн талбайд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй. Энэ зүйлд Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3 дугаар заалт болон Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.6 дугаар зүйл хамаарахгүй.”

2-р зүйл. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг дараахь байдлаар өөрчилсүгэй:

“2 дугаар зүйл. Ашиглалт явуулах нөхцөл хангагдсан, ордын тухайн жилд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлын 50 хувийг урьдчилан байршуулсан болон үлдэгдэл зардлын 50 хувьд дүйцэхүйц хэмжээний баталгаа гаргасан, хайгуулаар тогтоогдсон ашигт малтмалын нөөцийн хэмжээ, үнэлгээ нь олборлолтоос үүсч болох экологийн хохирлыг нөхөн сэргээхэд хүрэлцэх эсэх талаархи геологи, уул уурхайн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтарсан дүгнэлт, гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд хамаараагүй талаарх байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт, тухайн аж ахуйн нэгж ордыг ашиглаад бүрэн нөхөн сэргээж хүлээлгэж өгөх баталгаа зэргийг үндэслэн ашигт малтмал ашиглах, байгаль орчны нөхөн сэргээлтийн талаарх гэрээг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч, тухайн орон нутгийн аймгийн Засаг дарга нар хамтран 6 сарын дотор багтаан байгуулна.

3 дугаар зүйл. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “... зөвшөөрлийг энэ хууль батлагдсанаас хойш 5 сарын хугацаанд цуцална.” гэснийг

“... ашиглалтын зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 2, 3 дугаар зүйлд заасан шаардлагыг хүлээн зөвшөөрч үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийг хүсвэл энэ хууль батлагдсанаас хойш 6 сарын дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өргөдөл гаргана.” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2013 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд дараахь агуулгатай 56.1.7 дугаар заалтыг нэмсүгэй:

"56.1.7. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зүйл, заалт болон хуулийн дагуу байгуулсан гэрээний заалтыг зөрчсөн."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2013 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг